

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2022 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, аймгийн Засаг даргаас 6 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг тооцон ажилласан.

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлыг 1 удаа зохион байгуулан, 5 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Боржигин өв соёлоо өвлөн уламжлагч, Тив, дэлхий, улс бүсийн чанартай тэмцээнүүдэд амжилт гаргасан авьяаслаг сурагчдын нэгдсэн тоглолтыг Говьсүмбэр аймгийн Засаг даргын санаачилгаар аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Соёл, урлагийн газартай хамтран 250 авьяаслаг сурагчдын "БОРЖИГИНЫ ХҮҮХДҮҮД" урлагийн тайлан тоглолтыг 2022 оны 11 сарын 25-ны өдрүүдэд 2 удаа Монголын хүүхдийн ордонд зохион байгууллаа.

Говьсүмбэр аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын үе үеийн төгсөгчдийн дунд зохион байгуулагдсан аймгийн Засаг даргын нэрэмжит "НӨХӨРЛӨЛ - 2022" спортын 3 төрөлт анхдугаар бага наадам 2022 оны 11 сарын 11-ээс 13-ны өдрүүдэд Улаанбаатар хотын "Уран ган" спорт цогцолборт зохион байгуулагдсан. Тэмцээнд 1988-оноос 2021 оныг хүртэлх нийт 31 төгсөлтийн 1300 гаруй тамирчид оролцсон, өргөн хүрээг хамарсан спортын наадам болж өндөрлөлөө.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн санаачилгаар хэрэгжиж буй "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний орон нутаг дахь хэрэгжилтийг эрчимжүүлэх, иргэдийн оролцоог идэвхжүүлэх зорилгоор "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг албан ёсоор эхлүүлж, "Хүнсний хувьсгал" зөвлөгөөнийг 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулсан.

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Төрийн архив: Архивийн баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 1 хөмрөгийн 3 хадгаламжийн нэгж, 4158 заалт, 2108 хүний нэр, 423 байгууллагын нэр, 1257 газарзүйн нэр, 447 хуудас баримтыг программд холбож ажилласан. 2022 оны 11 дүгээр сард 9 иргэнд лавлагаа хуулбар гаргаж үйлчилгээ үзүүлсэн.

Улсын бүртгэлийн хэлтсээс 2022 оны 11 дүгээр сард дараах чиглэлээр нийт 783 иргэнд төрийн үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнд:

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан - 46
- Иргэний үнэмлэх шинээр олгосон - 102
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо - 41
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 10
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо - 2
- Овог, нэр өөрчлөлтийн бүртгэлийн тоо - 1
- Эцэг тогтоолтын бүртгэлийн тоо - 1
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 13
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо - 35
- Тоон гарын үсэг олголт - 11

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 11
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 16
- Гэрээний бүртгэл - 30
- Барьцааны гэрээний бүртгэл - 131

- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга - 5

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 4
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт - 8

Архивын чиглэлээр:

- Хуулийн этгээдэд гаргасан лавлагаа, хуулбар -15
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар - 299

Хууль сахиулах чиглэлээр: 2022 оны 11 дүгээр сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 105 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн 31, зөрчлийн 74 гомдол мэдээлэл байна. Тайлангийн хугацаанд зөрчил үйлдсэн 15 иргэнийг 2.300.000 төгрөгөөр торгож, согтуугаар зөрчил гаргасан 22 хүнийг эрүүлжүүлж, 18 хүнийг шүүхээр баривчлуулан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 42 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан байна.

Цагдаагийн байгууллагаас улсын хэмжээнд зохион байгуулж байгаа “Илрүүлэлт-оргодол” нэгдсэн арга хэмжээ, хүүхдийг бэлгийн хүчирхийлэл, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, далд хэлбэрээр үйлдэгдсэн хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн талаар мэдээлэл, цуглуулах, илрүүлэх, шалган шийдвэрлэх зорилгоор “Нуугдмал” арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэрт зохион байгуулж байна.

Сүмбэр сумын Хамтарсан багаас санаачилсан хүчирхийллийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх, нуугдмал хэрэг, зөрчлийг илрүүлэх, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээхэд дэмжлэг үзүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Хүчирхийлэлгүй гэр бүл-Хүчирхийлэлгүй ирээдүй” аяныг хамтран хэрэгжүүлж эхлээд байна.

Онцгой байдлын газар нь: Гэр хорооллын айл өрхүүдийг галын аюулаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд иргэн, аж ахуй нэгж байгууллагад галын аюулгүй байдлыг хангуулах урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт хяналт шалгалт зохион байгуулсан бөгөөд нийт 165 айл өрх хамрагдаж, 55 зөрчил дутагдлыг илрүүлж, газар дээр нь 22 зөрчлийг арилгуулж, 23 зөрчил дутагдлыг эргэн шалгах хугацаатай заавар зөвлөмж өгч, 341 иргэнд галын аюулаас урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгаа хийсэн.

“Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам”-ын дагуу 40 иргэн, аж ахуй нэгж байгууллагын гаргасан хүсэлтээр галын аюулгүй байдлыг шалган илэрсэн зөрчил дутагдалд мэргэжил арга зүйн зөвлөмж өгч, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт олгож 3.557.500 төгрөгийг тэмдэгтийн хураамжийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна.

ДӨРӨВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсролын чиглэлээр: Англи хэлний багш нарын мэргэжлийн хөгжлийг дэмжсэн 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан.

Аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчид “Бид дээрэлхэхгүй” аянд нэгдэж, үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг нөлөөллийн зохион байгуулж, давхардсан тоогоор таван сургуулийн 4471 сурагч, 234 багш, ажилтан, 78 эцэг эх хамрагдсан.

Боловсролын чанарын шинэчлэл, төслийн хүрээнд “Тоглонгоо суралцъя” дугуйлангийн тайлант өдөрлөг зохион байгуулж, дугуйлангийн 25 сурагчдад 2 дугаар шатны үнэлгээ хийж, сурлагын хоцрогдлыг арилгахад дэмжлэг үзүүлэх сургалтын хөтөлбөр арга зүйн сан бүрдүүллээ.

2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 5 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 7 байгууллагын үйл ажиллагаанд ахмад багш нарын зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа.

Соёл, урлагийн чиглэлээр: “Алсын хараа -2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор Соёлын яам, Засгийн

газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газраас “Соёлын бүтээлч сар”-ын үйл ажиллагааг улс орон даяар зохион байгуулж, үндэсний нэгдмэл үнэт зүйл, түүх соёлоо сурталчилан таниулсан. Тус аяны хүрээнд аймгийн Соёл урлагийн газраас 36 ажлыг төлөвлөн хэрэгжүүлж, 6989 хүнийг хамруулсан. Үүнд: “Боржигин судлал -2022” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгууллаа. Эрдэм шинжилгээний хуралд Боржигин 13 сумын удирдлага, соёлын төв, өвлөн уламжлагчдын төлөөлөл 200 хүн хамрагдлаа.

2022 оны 11 сарын 11-17-ны өдрүүдэд 4 жилд нэг удаа улсын хэмжээнд зохион байгуулагддаг Ардын Дуу Бүжгийн чуулгуудын уралдаанд "Боржигин" чуулгын уран бүтээлчид "Хөх тэнгэрийн нүүдэлчид" театрчилсан тоглолтоор оролцож “Шилдэг гоцлол бүжигчин” төрөлд 3-р байрт, “Шилдэг гоцлол хөгжим” төрөлд 3-р байрт, “Шилдэг найрал хөгжим” төрөлд 2-р байрт, “Шилдэг бүжиг дэглээч” төрөлд 2-р байрт тус тус шалгарсан байна.

Биеийн тамир, спортын чиглэлээр: Аймгийн Биеийн тамир спортын газрын анхны дарга, хүндэт дасгалжуулагч Сосорбурамын Балжиннямын нэрэмжит Жүдо бөхийн өсвөр үеийн аварга шалгаруулах олон хотын нээлттэй тэмцээнд аймгийн Биеийн тамир, спортын газар, Дорноговь, Дундговь, Бор-өндөр, Шивээговь сумын “Хаялага клуб”, аймгийн Ерөнхий боловсролын 2-р сургуулийн тамирчид бага, дунд, ахлах, насанд хүрэгчид гэсэн 4 ангилалийн 27 жинд 183 тамирчин хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

2022-оны 11-р сарын 08-13-ны өдрүүдэд Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотод зохион байгуулагдсан Олон улсын хэмжээний мастер Н.Ганхуяг багшийн нэрэмжит холимог насны олон хотын аварга шалгаруулах боксын тэмцээнд аймгийн боксын өсвөрийн тамирчид оролцож, 1 алт, 2 мөнгө 3 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 2-р байрт шалгарлаа.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Үзүүлэлт	2021 оны 11 сар	2022 оны 11 сарын 21-ний байдлаар
Төрсөн эх	423	327
Гэрийн төрөлт	3	2
Амьд төрсөн хүүхэд	429	325
Амьгүй төрөлт	1	3
Нас баралт	82	72
Эмнэлгийн нас баралт	28	21
Хоног болоогүй нас баралт	6	7
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	1	4
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	1
Эмнэлгээс гарсан хүний тоо	600	4804
Амбулаторийн үзлэг	90120	108122
Халдварт өвчин	5151	2575

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дархлаажуулалтын албанаас 2022 оны 11 дүгээр сарын 17, 18-ны өдрүүдэд аймгийн Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нарыг чадавхижуулах сургалт зохион байгуулж, Шивээговь сумын Эрүүл мэндийн төвийн дархлаажуулалтын нэгжид дэмжлэгт хяналт хийж, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан байна.

“Эрүүл мэндийг дэмжих сан”-гийн дэмжлэгтэйгээр 2022.10.17-11.01-ний хооронд хүн амд сүрьеэ өвчний талаар мэдээлэл, сурталчилгаа түгээх, сүрьеэгийн тохиолдлын хавьтал болон сүрьеэд өртөх эрсдэл бүхий иргэдийг үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж, 500 иргэнийг үзлэгт хамруулан сүрьеэ өвчний 2 шинэ тохиолдлыг эрт илрүүлэн эмчилгээнд хамруулж, халдварын тархалтыг бууруулахад үр нөлөө үзүүлсэн байна.

ЭМЯ-наас зохион байгуулсан Турк улсын Истанбул хотын Acibadem group-ын эмнэлэг, анагаах ухааны сургуульд аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга "Эмнэлгийн удирдлага зохион

байгуулалт, менежмент" чиглэлээр сургалтад хамрагдаж, Acibadem их сургуультай хамтарч ажиллах гэрээг байгуулан аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2 эмчийг сургалтанд хамруулахаар болсон.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр: Тайлант хугацаанд хуваарийн дагуу 149 иргэний эргэн төлөлтөд хяналт тавьж, 51 иргэний 21208,0 мян төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлж, өссөн дүнгээр 161 иргэний 188,922.8 мян.төгрөг халамжийн санд төвлөрөөд байна.

“Ногоон ажлын байр” хөтөлбөрийн хүрээнд мод тарих арга хэмжээнд 144 иргэнд 52591,3 мян, нийтийг хамарсан ажил 88 иргэнд 32533,6 мян төгрөг зарцуулсан байна.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Малчдын бэлтгэсэн өвс, тэжээлийн нөөц: 802 малчин өрх 4463 тн өвс, 245 тн гар тэжээл, үйлдвэрийн тэжээл 236 тн, ногоон тэжээл 115 тн, хужир 291 тн-ыг бэлтгээд байна. Малчин өрхийн өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэлт 66.8 хувь, малчин өрхийн өвөлжилтийн бэлтгэл хангалт 88.7 хувьтай байна.

Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар инженерийн хийцтэй 4 худаг шинээр гаргах ажил үргэлжилж байна. Сүмбэр суманд 2 худаг, Баянтал суманд 1, Шивээговь суманд 1 худаг тус тус гаргахаас гурван худгийн өрөмдлөгийн ажил хийгдэж дууссан.

“Шилмэл мал-2022” улсын үзэсгэлэн худалдаа цахимаар зохион байгуулагдаж, тус үзэсгэлэнд манай аймгаас 5 иргэн, 1 ААН нэгж 5 төрлийн 11 толгой малаар оролцож, тэргүүн байр 4, тусгай байр 2 шалгарч, нийт зургаан мал “Гойд ашиг шимт” малын батламж авсан.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 81 дүгээр тогтоолоор батлагдсан “Хоршооны хөгжлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2022 оны А/90 дугаартай “Төлөвлөгөө батлах тухай” тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хоршоодын хөгжлийн үнэлгээг зохион байгуулж, үнэлгээнд улсын бүртгэлтэй 38 хоршооноос 22 хоршооны 92 төлөөлөл буюу 57.8 хувь нь хамрагдсан.

Ургац хураалтын мэдээгээр 2022 онд 21 га-аас 177 тн төмс, 31.2 га-аас 247.6 тн хүнсний ногоон хураан авсан дүнтэй байна. Энэ нь тухайн жилийн төлөвлөснөөс төмсний тариалсан талбайг 2 га-аар, хүнсний ногооны тариалсан талбайг 4.2 га-аар нэмэгдүүлсэн байна. Хүнсний ногооны хангамж 24 хувь, төмсний хангамж 24.5 хувьтай байна.

Аймгийн дүнгээр мах 21 тн буюу 10, гурил 42.6 тн буюу 48, сүү 3.6 тн буюу 2, төрөл бүрийн будаа 22.4 тн буюу 29, төмс 16.1 тн буюу 10, хүнсний ногоо 17.9 тн буюу 5, элсэн чихэр 8.2 тн буюу 18, давс 5.4 тн буюу 18, савласан ус 25 тн буюу 1, өндөг 1.7 тн буюу 11, ургамлын тос 6.2 тн буюу 22 хоногийн нөөцтэй байна

Төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний Аймгийн үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2022 оны 11-р сарын үнийн мэдээ

Зах зээлд худалдаалагдаж буй зарим хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ өнгөрсөн сараас 250-500 төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал: Үхрийн мах, ямааны мах, хонины мах тус бүр 500 төгрөгөөр, төмс 250 төгрөгөөр, сонгино 250 төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

Үнийн мэдээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дотооддоо үйлдвэрлэж буй малын мах төрөл тус бүрээр 250-500 төгрөгөөр, төмс, хүнсний ногоо 50-100 төгрөгөөр, сүү 500 төгрөгөөр, гурил 50-150 төгрөгөөр буурсан бол импортын бүтээгдэхүүн болох элсэн чихэр 200 төгрөгөөр, цагаан будаа 500-1000 төгрөгөөр, ургамлын тос 1000-1500 төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

№	Бараа бүтээгдэхүүн	Дээд үнэ төг	Доод үнэ төг	Өссөн буурсан	
1	Үхрийн мах	Ястай	9500	8500	-500
		Цул	11000	10000	-500
2	Хонины мах	Ястай	5500	5000	-500
		Цул	8500	7500	-500
3	Адууны мах	Ястай	8000	6500	
		Цул	9000	9000	
4	Ямааны мах	Ястай	6000	4500	-500
		цул	8000	8000	-500
5	Тахианы мах	Гуя	12000	10500	
		мөч	14300	11000	
6	Лууван	монгол	2500	2000	
		хятад			
7	төмс	монгол	500	500	-250
		хятад			
8	Байцаа	монгол	1500	1600	
		хятад			
9	чинжүү	монгол			
		хятад	5000	8500	
10	Манжин	монгол	2800	1400	
		хятад			
11	Сонгино бөөрөнхий	Монгол	2000	2000	-250
		Хятад			
12	Помидор	монгол	6500	6000	
13	Өргөст хэмх	монгол	6500	6000	
14	Элсэн чихэр	монгол	3250	2900	
15	Будаа	Цагаан задгай кг	3350	3000	
		Шар слава кг	5100	3000	
		Гурвалжин будаа кг	6000	4000	
16	Сүү	Задгай	3000	2800	
		Сүү ХХК 0,5л			
		Сүү ХХК 1л	4300	4000	
17	Тараг	Задгай	3500	3000	
		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	5500	3800	
18	Талх	Чойр талх	1900	1500	
19	Өндөг	ОХУ	400	330	
		Монгол	450	400	
20	Алтан тарианы гурил	Задгай дээд	1500	1300	
		Задгай 1-р зэрэг	1950	1500	
		Задгай 2-р зэрэг	1400	1000	
		Савласан д/дээд /	2400	2400	
		Савласан дээд	2200	1800	
		Савласан 1-р зэрэг	1950	1400	
		Савласан 2-р зэрэг	1200	1000	
21	Ургамлын тос	Олейна	10000	9500	
		Алтан	8000	7500	

22	Гоймон	Алейка	2800	2000	
		А/тариа савхан	1800	1000	
		А/тариа савхан	1800	1000	

Орон даяар зохион байгуулагдаж байгаа "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний нээлтийн үйл ажиллагааг аймгийн хэмжээнд 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулсан. Энэхүү нээлтийн үйл ажиллагааг Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх Ч.Даваабаяраар ахлуулсан ажлын хэсэг болон аймгийн Засаг дарга, Хүнс, хөдөө, аж ахуйн газартай хамтран зохион байгуулсан. Уг арга хэмжээний хүрээнд аймаг орон нутгийн хөгжилд тодорхой хувь нэмрээ оруулж буй аж ахуйн нэгж, ялангуяа хүнсний үйлдвэрлэлд өөрийн бүтээгдэхүүн, брендээр тэргүүлж буй хоршоодын үйл ажиллагаатай танилцсан юм. Нээлтийн арга хэмжээнд аймгийн Засаг дарга, хүнсний үйлдвэрлэл эрхлэгчид, баялаг бүтээгчид, сумдын удирдлагууд, төрийн албан хаагчид нийт 166 хүн оролцсон.

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Байгаль орчны чиглэлээр: Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр: Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 21 аж ахуйн нэгж, байгууллагын 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянасан.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар шинэчлэн батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хэрэгжилтийг хангуулах зорилгоор сумдын Засаг дарга нарт чиглэл хүргүүлж хамтран ажиллаж байна.

2022 онд модны урамшуулалд хамрагдах иргэн, аж ахуйн нэгжийн модны тооллого зохион байгуулж, 17 иргэн, 3 аж ахуйн нэгжид 34,4 сая төгрөг олгохоор болсон.

Говьсүмбэр аймаг Засаг дарга болон Дорноговь аймгийн Засаг дарга нарын хамтарсан 2021 оны А/358, А/605 дугаар захирамжаар улсын тусгай хамгаалалттай Чойрын богд уулын орчны хамгаалалтыг сайжруулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Орчны бүсийн зөвлөл” байгуулагдсан. Тус зөвлөлийн анхдугаар хуралдааныг 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгууллаа. Тус хуралд аймгийн Засаг даргын орлогч Сүмбэр сумын Засаг дарга ТБайгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг дарга, Байгаль орчин, Аялал жуулчлалын газрын мэргэжилтэн, Их нартын тусгай хамгаалалттай газрын захиргааны дарга, аймгуудын малчдын төлөөлөл, “Уулзварын гол” нөхөрлөлийн төлөөлөл гэсэн 25 хүн хамрагдаж “Орчны бүсийн зөвлөл”-ийн дүрмийг танилцуулж, хурлын дэг, цаашид хамтран ажиллах төлөвлөгөөг баталж, аймгийн төлөөллүүд улсын тусгай хамгаалалттай “Чойрын богд уул” орчмын малчдын асуудал, орчны газрын хамгаалалт, бэлчээр хамгааллын асуудал, хилийн цэсийн асуудал, ан, амьтан ургамал хамгаалал, отор нүүдлийн тулгамдсан асуудлуудыг хамтран хэлэлцэж шийдвэрлэх болон хамтын үйл ажиллагааг тогтмолжуулан ажиллах зэрэг асуудлуудыг хэлэлцлээ.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр ээлжит бус хуралдаанаар 2023 онд иргэдэд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг хэлэлцүүлж, 261 иргэнд 18.97 га газрыг өмчлүүлэх саналыг Засгийн газраар батлуулахаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлсэн.

2022 оны 11 сарын байдлаар ажил нь үргэлжилж буй 7 ажилд зураг төсөл, гэрээний дагуу захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Гамшгийн эрсдлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 12 сая төгрөгөөр нийтийн зориулалттай 3 орон сууцыг паспортжуулах ажлыг “Бүүвэй цагаан барс” ХХК-иар

гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, хэмжилт боловсруулалтын ажлыг хийсэн. Ажлын гүйцэтгэл 95 хувьтай явагдаж байна.

Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагааны талаар: Төсвийн ерөнхийлөн захирагчид 2022 онд нийт 15,815,162.8 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 49 бараа, ажил, үйлчилгээ худалдан авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласан байна. Үүнээс 48 тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарласан. Худалдан авах ажиллагааны явц 97.9 хувьтай байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 11,105,600,0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий нийт 5 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 5 ажил буюу 100 хувь, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2,610,898.1 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий нийт 25 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 25 ажил буюу 100%, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 1,676,208,9 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий нийт 16 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 16 ажил буюу 100%, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 92,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий нийт 2 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 2 ажлын тендер шалгаруулалтыг, Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар 330,455.8 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий нийт 1 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 1 ажлын тендер шалгаруулалтыг тус тус цахимаар зохион байгуулаад байна.

Баянтал сум: Өвөлжилтийг бэлтгэх ажлын хүрээнд сумын Засаг дарга болон багийн Засаг дарга нар сумын 1, 2-р багийн айл өрх, малчин айл өрхүүдээр явж өвөлжилтийн бэлэн байдалтай танилцлаа.

Сумын залуучуудын санаачлагаар 2022 оны 11-р сарын 7, 8-ны өдрүүдэд спортын бага наадам зохион байгуулав. Тус арга хэмжээнд нийт 13 баг оролцсон.

Шивээговь сум: “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан “Сайн засаглал”, “Ухаалаг засаглал”, “Цахим засаглал”-ыг бий болгох зорилтын хүрээнд төрийн үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд иргэдэд өөртөө үйлчлэх цахим цэгийг бий болгон сумын Засаг даргын Тамгын газрын нэгдсэн үйлчилгээний төвд байршуулан ажиллаж байна.

Сүмбэр сум: Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Цагдаагийн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газартай хамтран отор, нүүдлийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, отроор орж ирсэн Өвөрхангай аймгийн 4, Хэнтий аймгийн 1 айлд албан мэдэгдэл өгсөн. Одоогийн байдлаар отрын бүсээс гадна 7 айл өрхийн 3680 толгой мал зөвшөөрөлгүй орж ирээд байна.

Архи согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрөл сунгуулахаар 4 аж ахуйн нэгжийн 6 хүнсний дэлгүүр, шинээр тусгай зөвшөөрөл авахаар 1 аж ахуйн нэгж ажлын хэсэгт материал ирүүлснээс 3 аж ахуйн нэгжийн 5 дэлгүүр тусгай зөвшөөрлийг сунгаж, 1 аж ахуйн нэгжид шинээр сул агууламжтай согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрөл олгосон.

Сумын хэмжээнд золбин нохой, муур устгах ажлыг “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ 11 дүгээр сарын 08-наас 10-ны хооронд зохион байгуулж 188 нохой, 88 устгаж төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлж, ариутгал хийж ажилласан.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР